

МАЛЧДЫН АМЬДРАЛД УУЛ УУРХАЙН ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ (Доргонт багийн жишээн дээр)

Ц.ЦЭЦЭГЖАРГАЛ

МУИС, ШУС, Антропологи, археологийн тэнхим,
e-mail: tgl@num.edu.mn

ТҮЛХҮҮР ҮГ: Уул уурхай, байгаль орчны өөрчлөлт, нүүдлийн соёл, мал аж ахуй

ХУРААНГУЙ: Алт-1, Алт-2000 хөтөлбөрүүдийн золиос болсон Заамар нутагтай хил залгаа Булган аймгийн Дашинчилэн сумын Доргонт багийн нутагт алтны уурхайн үйл ажиллагаа эрчимжих болсон учраас байгаль орчин, малчдын амьдралын хэв маягт үзүүлж буй уул уурхайн үйл ажиллагааны нөлөөллийг судлах зорилгоор 2016 оны 8 дугаар сард тус багт хээрийн судалгаа (ярицлага, ажиглалт) хийн судалгааны эх хэрэглэгдэхүүн цуглууллаа. Доргонтын газрын хөрс зөөлөн, ус хужир элбэгтэй, ногоо сайтай, өвөлдөө цас бага унадаг тул мал өсгөхөд таатай нутаг учраас малчид хонь, ямаа, үхрийг махны чиглэлээр өсгөж ирсэн. Сүүлийн жилүүдэд тус багийн нутагт уул уурхайн үйл ажиллагаа эрчимтэй явагдах болсон байна. Судалгаагааны дүнгээс харвал Алтан дорнод компаний алт олборлолтоос үүдэн газар нутгийг идэвхтэй ашиглах бололцоо хязгаарлагдах, газрын гадаргыг сүйтгэх, гадаргын ус бохирдох болон ширгэх, ан амьтан болон ургамлын төрөл зүйл цөөрөх зэргээр тус нутгийн байгаль орчны бүрэн бүтэн байдал алдагджээ. Ийнхүү ил аргаар олборлолт хийж байгаа алтны уурхайн үйл ажиллагааны байгаль орчинд үзүүлсэн сөрөг нөлөө өнөөгийн малчдын амьдралд шууд ба шууд бусаар нөлөөлж, урт хугацаандаа малчдын тогтвортой амьжиргааг хангахад сөрөг үр дагавар үзүүлэх, малчдын эрх зөрчигдөхөд хүргэх төлөвтэй байна.

TS. TSETSEGJARGAL

THE IMPACT OF MINING ON THE LIVELIHOODS OF HERDERS

KEYWORDS: Mining, environmental change, nomadic culture, livestock

ABSTRACT. In August 2016, we conducted fieldwork to study the impact of mining activities on the environment and the lifestyle of herders in the Dorgont Bag area of Dashinchilen Sum, Bulgan province. The team collected field research materials (interviews and observations). The herders in the Dorgont bag have traditionally been raising sheep, goats, and cattle as the land in the area is an appropriate place to raise livestock. In recent years, mining activities rapidly increased in the Dorgont area. According to the results of the study, due to the gold mining of the 'Altan dornod Mongol', the integrity of the environment has been lost by limiting the ability of herders to actively use the land, destroying the surface, contaminating, and drying up the surface water, and reducing the species of animals and plants. This way, the negative impact of gold mining on the environment directly and indirectly affects the lives of herders, and in the long run, it is expected to have negative consequences for the stable livelihood of herders and to violate herders' human rights.

Монгол оронд Орос, Хятадын хамтарсан “Монголор” нийгэмлэг анх алт олборлож эхэлсэн байдаг бөгөөд, 1923 онд Уурхайн дүрэм батлагдсанаар үйл ажиллагаа нь зогсоож, Баянхонгорын уурхай (1939), Бороогийн уурхай (1948) зэрэг улсын алтны уурхайнууд байгуулагдаж эхэлсэн түүхтэй. Социализмын жилүүдэд Монгол орны нийт нутаг дэвсгэрт геологийн зураг гаргах, уул уурхайд ажиллах боловсон хүчин бэлтгэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг шат дараалан хэрэгжүүлснээр уул уурхай нь монголын эдийн засгийн томоохон салбар болсон юм (Мэттэ Хай 2011).

1990-ээд оны эдийн засгийн хүндрэлээс гарахад уул уурхайн баялгийг эдийн засгийн тулгуур болгоход анхаарч манай улсад 1992-99 онд Алт-1 хөтөлбөр, 2000 оноос Алт-2000 хөтөлбөрийг баталсан. Алт хөтөлбөрүүд амжилттай хэрэгжихэд: 1.Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт нэмэгдсэн; 2.Салбарын мэргэжилтэй боловсон хүчин, техник технологийн бааз суурь хангалттай байсан; 2.Эрдэс баялгийн арвин нөөцтэй зэрэг таатай нөхцөл бүрдсэн зэрэг олон хүчин зүйл нөлөөлжээ. Шилжилтийн жилүүдэд уул уурхай, ялангуяа алтны аж үйлдвэрлэл эрчимтэй хөгжиж, монголын эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болсноор эдийн засгийн хүнд үеийг даван туулахад гол нөлөө үзүүлсэн.

Гэвч уул уурхайн үйлдвэрлэл эрчимжихийн хэрээр усны алдагдал, байгаль орчны бохирдол зэрэг сөрөг үзэгдлүүд ихсэж, уламжлалт нүүдлийн амьдралын хэв маяг өөрчлөгдөх, соёлын биет болон биет бус дурсгалуудын хадгалалт хамгаалалтанд сөрөг нөлөө үзүүлэх зэрэг эрсдлүүд гарч байна. Тухайлбал, Алт-1 болон Алт-2000 хөтөлбөрийн цөм болох Заамар дахь алтны уурхайн олзворлолтын үйл ажиллагааны улмаас:


1. Олон мянган га газар эвдрэлд орсон
2. Усны бохирдол ихэссэн
3. Эко систем нь ноцтой гэмтэж цөлжсөн (80 төрлийн ургамал ургаж, бугын сүрэг бэлчдэг байсан нутаг эдүгээ бүхэлдээ цөлжжээ)
4. 50 гаруй уул уурхайн компани үйл ажиллагаа явуулсан боловч нэг ч га талбайд нөхөн сэргээлт хийгээгүй
5. Нутаг дэвсгэрээс нь 120 тонн алт олборлосон атал Заамар хөгжлийн хувьд хамгийн хоцрогдсон сум (Сонинбаяр, 2019) болж үлдсэн зэрэг сөрөг үр дагавар гарчээ.

Эдүгээ ч уул уурхайн салбарын монголын эдийн засагт гүйцэтгэх үүрэг өндөр хэвээр бөгөөд Эдийн засгийг сэргээх хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор “Алт-2” хөтөлбөрийг 2017 онд Монгол улсын Засгийн газраас баталж хоёр үе шаттай хэрэгжүүлсэн. Энэ үеэс өмнөх хөтөлбөрүүдийн алдаанаас сургамж авч байгаль орчны нөхөн сэргээлтийн асуудлыг бодлогын түвшинд гаргаж, шийдвэрлэхэд анхаарч байгаа ч орон нутгийн нийгэм, эдийн засаг, соёлын хүрээнд болон нутгийн иргэд, малчдын амьдралд хэрхэн нөлөөлж байгаад огт анхаарал хандуулахгүй байна.

Алт-1, Алт-2000 хөтөлбөрүүдийн золиос болсон Заамар нутагтай хил залгаа Дашинчилэн сумын Доргонт багийн нутагт алтны уурхайн үйл ажиллагаа эрчимжих болсон учраас байгаль орчин, малчдын амьдралын хэв маягт нөлөөлөх уул уурхайн үйл ажиллагааны нөлөөллийг судлах зорилгоор манай судалгааны баг 2016 оны 8 дугаар сард тус багт хээрийн судалгаа (ярилцлага, ажиглалт) хийн судалгааны эх хэрэглэгдэхүүн цуглууллаа.

Доргонт багийн нутаг байгалийн мужлалтын хувьд Орхон-Туул голын сав газрын нам уул, хотгор бүхий хуурай хээрийн дэд мужид хамрагдах бөгөөд Туул гол, Харбухын гол зэрэг голууд урсана. Доргонт багийн араар уулын тайгын нугын цэвдэгт хөрс, өмнүүр ойт хээрийн ба хээрийн нугын хээршсэн хөрстэй. Ургамлын хувьд олон наст, өвсөрхөг тал хээрийн ургамалтай. Байгалийн баялгийн хувьд алтнаас гадна барилгын сайн чанарын материал болох элс, шохойн болон будгийн чулуу, цагаан шавар, малын хужир зэрэг байгалийн баялаг ихтэй (Чулуун-Эрдэнэ, 2015:8-9).

1961 онд Дашинчилэн суманд үржил, зохиомол хээлтүүлгийн станц байгуулснаар эрлийз хонь маллахаар сумын төв болон бусад сумаас Доргонтод олон хүн ирж суурьшжээ.



Эх сурвалж: <https://www.1212.mn/mn/>

Зураг 1. Доргонт багийн хүн ам

Харин 1990-ээд оноос хойш шилжилт хөдөлгөөн чөлөөтэй болсон; нийгэм, эдийн засгийн дэд бүтэц хангалтгүй; зуд зэргээс шалтгаалан хүн ам буурах хандлагатай болсон. Сүүлийн жилүүдэд тус нутагт цаг агаарын байдал тогтвортой, Улаанбаатар хотруу чиглэсэн шилжилтийг хязгаарласан зэрэг нь хүн амын тоо харьцангуй тогтвортой байхад нөлөөлсөн байна. Доргонтын газрын хөрс зөөлөн, ус хужир элбэгтэй, ногоо сайтай, өвөлдөө цас бага унадаг учраас мал өсгөхөд таатай нутаг. Малчид хонь, ямаа, үхрийг махны чиглэлээр өсгөдөг, дунджаар 400-500 толгой малтай, мөн цөөнгүй 1000-аас дээш толгой малтай малчин байна. 40-өөс дээш насны малчдын хувьд Туяа нэгдлээс хувьчилж авсан, харин залуучууд эцэг, эхээс өмч болгон тасалж өгсөн малаа өсгөж байна.

Сүүлийн жилүүдэд Доргонт багийн нутагт уул уурхайн үйл ажиллагаа эрчимтэй явагдах болжээ. 2015 оны 2-р сарын байдлаар Алтандорнод Монгол компани Доргонот, Улаан ухаа хэмээх талбайнуудад нийт 7203.33 га ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшиж байлаа (*Mont_Report_2015-2sar.xls (live.com)*). Биднийг судалгаа хийж байх үед Доргонт багт Алтандорнод монгол компани уул уурхайн үйл ажиллагаа явуулж, Цагаан-Уулын магнит кампани үйл ажиллагаа эхлүүлэх бэлтгэл ажил хийж байлаа.

Судалгааны талбар болох Булган аймгийн Дашинчилэн сумын Доргонт багийн нутагт 2016 онд хийсэн хээрийн судалгаагааны дүнгээс харвал алт олборлолтоос үүдэн нутгийн малчин иргэдийн газар нутгийг идэвхтэй ашиглах бололцоо хязгаарлагдах, газрын гадарга сүйтгэгдэх, гадаргын ус бохирдох болон ширгэх, ан амьтан болон

ургамлын төрөл зүйл цөөрөх зэргээр уул уурхайн үйл ажиллагаа тус нутгийн байгаль орчны бүрэн бүтэн байдалд таагүй нөлөө үзүүлжээ.

Хүснэгт 1. Доргонт багийн нутагт олгогдсон уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөл

№	Тусгай зөвшөөрөл	Талбайн нэр	Талбайн хэмжээ	Эзэмшигч
1.	Ашиглалтын тусгай зөвшөөрөл 2015.04.29	Доргонот, Улаан ухаа MV-022121	269.28	Батбродерс майнинг
2.	Ашиглалтын тусгай зөвшөөрөл 2021.06.29	Доргонот, Улаан ухаа MV-021915	1149.49	ПЛ майнинг (Шилжүүлж авсан)
3.	Ашиглалтын тусгай зөвшөөрөл 2021.06.29	Доргонот, Улаан ухаа MV-021914	1492.43	ПЛ майнинг (Шилжүүлж авсан)
4.	Ашиглалтын тусгай зөвшөөрөл 2015.04.29	Доргонот, Улаан ухаа MV-020717	204.33	Цагаан-Уулын магнит

Эх сурвалж: Булган аймгийн Ашигт... , 2023

Уул уурхайн үйл ажиллагаа Доргонт багийн байгаль орчинд үзүүлсэн нөлөө:

- Хөрс, ургамлын бүрхэвчийн эвдрэл
- Газрын гүний болон гадаргын усны чанар, хүртээмж багасах бохирдох
- Амьтдыг түйвээх
- Агаарын чанар муудах, тоосжилт ихсэх
- Дуу чимээ, чичиргээ зэргээр шууд нөлөөлөл үзүүлж богино хугацаанд байгалийн унаган хэв шинж алдагдахад хүргэжээ.

Уул уурхайн үйл ажиллагаа Доргонт багийн малчдын амьдралд үзүүлсэн нөлөө:

Ил аргаар олборлолт хийж байгаа алтны уурхайн үйл ажиллагааны байгаль орчинд үзүүлсэн сөрөг нөлөөлөл нь малчдын амьдралд шууд ба шууд бусаар нөлөөлж байна. Тухайлбал:

1. Газар нутгийг идэвхтэй ашиглах бололцоо хязгаарлагдсантай холбоотой малчдын амьдралд гарсан өөрчлөлтүүд:

- Зарим айлын намаржаа, хаваржаа уурхайн бүсэд орсон учраас өвөлжөө, зуслан хоёртой үлджээ. Энэ нь нүүдлийн урт болон давтамжийг хязгаарлаж, тодорхой газар нутагт бэлчээрийн даац хэтрэх, бэлчээр талхлагдахад хүргэхийн зэрэгцээ нутгийн малчдын дунд малын бэлчээр, бууж суух газраас үүдэлтэй маргаан гарах болсон.
- Бэлчээрийн хомсдолоос улбаалан хадлан хаддаг талбайдаа малчин айлууд буух болсноор хадлан бэлтгэх үйл ажиллагаа хумигдаж Баян нуурын тэжээлийн аж ахуйгаас хадлан, өвс тэжээлээ авах болсон.

2. Газрын гадаргыг сүйтгэсэнтэй холбоотой малчдын амьдралд гарсан өөрчлөлтүүд:

- Алтны компаний ашиглалтын талбай, зам хааснаас сумын төв орох болон хадлан тэжээлээ татахын тулд илүү тойруу замаар ирж очих болсон нь цаг хугацаа, эдийн засгийн хувьд ихээхэн хохиролтой байгаа нь ажиглагдсан.
- Алтны уурхайн ашиглалтын талбайн ухсан нүхэнд болон алт угаагаад хуримтлагдсан усан санд мал унаж үхэх явдал ихэссэнтэй холбоотойгоор малыг дагаж хариулах шаардлагатай болж байгаа нь хүн хүч муутай малчин өрхийн хувьд ачаалал болж байна.

3. Гадаргын ус бохирдох болон ширгэхтэй холбоотой малчдын амьдралд гарсан өөрчлөлтүүд:

- Туул гол руу алт угаасан усаа цутгаж бохирдуулснаас малчид ундны усаа сумын төвөөс эсвэл Заамарын гүүрэн дээр байдаг худгаас зөөх болсон.
- Алтны уурхай газрын гүнээс цэвэр ус татаж алт угаадаг болсноор Хадат булаг ширгэж, Хар бухын голын ундрага багассан нь малаа Туул голын бохирдсон усаар услахад хүрчээ. Бохирдсон усаар ундаалж буй малын гаралтай бүтээгдэхүүнийг хэрэглэж байгаа малчид өөрсдийн эрүүл мэндэд санаа зовох нь ихэсч байна.

4. Ургамлын болон ан амьтны төрөл зүйл цөөрсөнтэй холбоотой малчдын амьдралд гарсан өөрчлөлтүүд:

- Тоосжилт ихэссэн, газрын гүний ус хомсодсон, бэлчээрийн даац хэтэрснээс болж тус багийн нутагт ургаж байсан 30 гаруй төрлийн ургамлаас одоо 10 гаруй төрлийн ургамал, тэр дундаа хөл газрын ургамал буюу бидний нэрлэж заншсанаар шарилж, лууль зонхилон ургах болжээ. Ийнхүү газрын гарц муудсан нь малын чанарт нөлөөлж малчдын хадлан тэжээлд зарцуулах зарлагыг нэмсэн байна.
- Тарга тэвээрэг аваагүй төл малдаа эх малын сүүг хөхүүлэх болсноор хоногт хоёр удаа саадаг байсан үхрийг нэг удаа саах, өдөрт нэг удаа саадаг байсан хонь ямааг саахаа больжээ.
- Таана, мангир түүж малын тэжээл хийдэг, хадлан хаддаг өв уламжлал бараг мартагдсан байна.
- Байгаль орчны болон нийгэм, эдийн засгийн нөлөөгөөр сүргийн бүтцэд бод малын эзлэх хувь багассанаар бод мал маллагааны арга ажиллагаа, уналга ачлагад хэрэглэхтэй холбоотой олон биет бус соёлын өвүүд улиран мартагдаж байна.

Уул уурхайн байгаль орчин, малчдын амьдралд үзүүлсэн нөлөө түүний үр дагавар:

Алтны уурхайн байгаль орчин, малчдын амьдралд үзүүлж буй нөлөөлөл нь малчдын тогтвортой амьжиргааг хангахад сөрөг нөлөө үзүүлж байна.

- Хүний капитал (малчид шилжин суурьшихад сэтгэл зүйн хувьд бэлэн болсон, уул уурхайн үйл ажиллагаанаас шууд болон шууд бус хамаарсан эрүүл мэндийн асуудлууд урган гарч эхэлсэн гм)
- Нийгмийн капитал (Хувь хүн, ураг төрлийн болон бусад бүлгийн эрхээ хамгаалах, шийдвэр гаргах үйл явцад оролцох оролцоо хангагдахгүй байна)
- Эдийн засгийн ба санхүүгийн капитал (Уул уурхайн үйл ажиллагаа малчдын хүний хөгжил, амьжиргаа болон орон нутгийн хөгжилд ямар ч хувь нэмэр оруулахгүй байна)
- Биет капитал (Цэвэр усаар хангах гүний худаг байгуулж өгөх амлалтандаа хүрээгүй, мөн бусад баг сумдтай холбогдох дөт замыг хаасан, өвөлжөө хаваржааны зөвхөн газрыг үнэлж нөхөн олговор олгодог, бэлчээрийн хомсдолд

хүргэдэг) гэх мэтээр малчдын болон орон нутгийн тогтвортой хөгжилд ямар ч хувь нэмэр оруулахгүй байна.

Алтны уурхайн байгаль орчин, малчдын амьдралд үзүүлж буй нөлөөлөл нь малчдын эрх зөрчигдөхөд хүргэж байна.

- Эрүүл аюулгүй орчинд амьдрах,
- Амьжиргааны эх үүсвэрээ сонгох ба хамгаалуулах,
- Өмчлөх, аж ахуй эрхлэх,
- Уламжлалт соёл, ёс заншлаа хадгалах, өвлүүлэх,
- Байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах,
- Цэвэр усаар хангагдах,
- Шийдвэр гаргахад оролцох зэрэг хүний эрхүүд зөрчигдөхөд хүргэж байна.

ДҮГНЭЛТ

Олон зуун жилийн турш харилцан шүтэлцээтэй, цогц байдлаар харьцангуй тогтвортой оршин тогтнож ирсэн байгаль орчин, мал, нүүдлийн амьдралын хэв маяг гурав нь цаг агаарын өөрчлөлт, орчин үеийн улс төр, нийгэм-эдийн засаг, соёлын нөлөөнд маш хурдацтай өөрчлөгдөж байна. Эдийн засагт ашигтай ч, байгаль орчинд сөргөөр нөлөөлж байдаг уул уурхайн үйлдвэрлэл дэлхийд алдартай нүүдлийн соёлд аюулын харанга дэлдэж, байгаль орчны байдлаас шууд хамааралтай малчдын амьжиргааны эмзэг байдлыг бий болгож байгаа нь засаг захиргааны хамгийн бага нэгж болох нэг багийн жишээн дээр илхэн харагдаж байна. Байдал энэ хэвээр үргэлжилбэл амьжиргаагүй, мал маллагааны дэд бүтэцгүй, өвлүүлэх хөрөнгөгүй, нүүдлийн мал маллагааны соёлоо өв залгамжлуулах боломжгүй болсон малчин өрхийн тоо өссөөр байх хандлагатай байна.

Тогтвортой хөгжил, ногоон эдийн засаг дэлхий нийтийн зорилт болсон энэ цаг үед монгол үндэстний дархлаа болсон нүүдлийн соёл, түүний өв уламжлалыг хадгалан үлдээх, соёлын бүтээлч үйлдвэрлэл болгон хөгжүүлэх, малчдын тогтвортой амьжиргааг хангах, байгаль орчны тогтвортой хөгжлийг дэмжихэд чиглэгдсэн сургалт, судалгааг өргөжүүлэх; хөгжлийн бодлого шийдвэрт тусгах; хэрэгжүүлэх; эл асуудлаархи төр засаг - иргэний нийгэм - бизнесийн салбар - иргэдийн хамтын ажиллагааг бодлогоор дэмжих шаардлагатай нь харагдлаа.

НОМ ЗҮЙ

Булган аймгийн Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн мэдээлэл, 2023.01.03.
<http://bulgan.gov.mn/userfiles/files/20230103%20%D0%B0%D1%88%D0%B8%D0%B3%D0%BB%D0%B0%D0%BB%D1%82.pdf>

Бямбажав Д., бусад., 2017. Хариуцлагатай уул уурхай: сургалтын гарын авлага. УБ

Мэтэ Мэри Хай., 2011. Аюултай хишиг: Монголын албан бус алтны уурхайн эдийн засаг дахь хөрөнгө ба эцэгчлэл. УБ

Састэйнабилити Ийст Эйжия., 2014. Монгол Улсын уул уурхайн салбарын байгаль орчин, нийгмийн стратегийн үнэлгээ. Уул уурхайн яам. УБ

Сонинбаяр Г., 2019. Адлагдсан ч аминд орсон алт хөтөлбөрүүд. <http://eagle.mn/r/55330>.

Тогтвортой Хөгжлийн Олон Улсын Институт., 2017. ЗГХФ. Уул уурхайн бодлогын үзэл баримтлалын үнэлгээ. УБ.

Чулуун-Эрдэнэ Г., 2015. Булган аймгийн Дашинчилэн сумын газар зүйн тодорхойлолт. УБ